

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Засварын багаж, хэрэгсэл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭТТ/201907391 дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,
Финанс төв 5 давхар, 503тоот, Улаанбаатар-15160,
Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтэс
Утас: 75055555-511**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|--|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

**8. Гэрээ байгуулах
эрх олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Үнийн саналыг жишиг маягтын дагуу ирүүлэх:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 2. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг ижил төстэй бараа нийлүүлж байсан гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээлэгч байгууллагын тодорхойлолт ирүүлэх; 3. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/ 4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/ 5. Нийлүүлэх барааны стандартыг тогтоосон баталгаажуулалтын гэрчилгээ эсхүл тусгай сертификат, бусад баримт бичгийн жагсаалтыг ирүүлэх; 6. Техникийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг үйлдвэрийн каталогоор нотолж ирүүлэх; 7. Тендерт санал болгосон үнээр, санал болгосон хугацаанд техникийн тодорхойлолтын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлэх;
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын www.tender.gov.mn/ цахим системд ирүүлэх</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхарт нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

Дөрөв. **ЗАСВАРЫН БАГАЖ,
ХЭРЭГСЛЭЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Зорилго:

Салбарын автомашин техник, тоног төхөөрөмжүүдийн урсгал засварын ажил үүрэгт ашиглагдах сайн чанарын багаж хэрэгслэлээр хангахад оршино.

2. Нийлүүлэгчид тавигдах шаардлага

2.1 Нийлүүлэгчид тавигдах ерөнхий шаардлагын жагсаалт

- ✓ Захиалагчид нийлүүлэх багаж хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байна.
- ✓ Үйлдвэрийн стандарт баталгаажуулалт, хэмжилт туршилтын баталгааны хуудастай байна.
- ✓ Гинж, уян татлага, гинж холбох хэрэгсэлд мэдээлэх пайз байх ба, пайзанд бүх мэдээлэл байна.
- ✓ Багажны хэмжээ, загвар нь олон улсын стандартад нийцсэн байна.

2.2 Тоног төхөөрөмжийн чанар

- ✓ Гангийн марк засварын багажид тохирсон байх. / CrV-6140, CrV-6150 гантай дүйцэхүйц/

2.3 Нийлүүлэх бараа материал нь:

- ✓ Yato брэндийн багажтай дүйцэх

3. Шаардагдах бичиг баримт

3.1 Гүйцэтгэх ажлууд, ажил үйлчилгээний үе шатны хуваарь

- ✓ 2019 оны 9-р сар




3.2 Нийлүүлэгчээс шаардах тусгай зөвшөөрөл, стандартыг тогтоосон тусгай сертификат, бусад баримт бичгийн жагсаалт





- ✓ Бүх багаж батагаажуулалтын гэрчилгээтэй байна.
- ✓ Туршилт, шалгалт хийж баталгаажуулсан баталгааны хуудастай байна.

3.4 Хавсралт 1-ээр хавсаргав

Засварын багаж, хэрэгслэлийн техникийн тодорхойлолт		
Нийтлэг шаардлага	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэх багажинд баталгаа олгодог байх 2. Багаж нь сайн чанарын Монгол улсад танигдсан бренд байх 3. Засварын хэрэгцээнд зориулан үйлдвэрлэгдсэн байх 4. Гангийн марк засварын багажид тохирсон байх. / CrV-6140, CrV-6150 гантай дүйцэхүйц/ 5. Багажны хэмжээ, загвар нь олон улсын стандартад нийцсэн байх 6. Захиалагчид нийлүүлэх багаж, хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан үзүүлэлтээс зөрөөгүй байна. 	
Амтай түлхүүрт тавигдах шаардлага	<p>Түлхүүр нь бүгд миллиметрийн хэмжээтэй байх</p> <p>Уутан дотроо 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 30, 32мм-ийн хэмжээтэй түлхүүртэй байх</p> <p>Түлхүүр нь авч явахад хялбар байхаар бат бөх ууттай байна</p> <p>Түлхүүр нь бүгд ашиглалтын явцад зэврэхгүй байхаар никелдсэн байх</p> <p>Гангийн хатуулаг зориулалтаас хамаарч HRC 50-60 хооронд байх</p>	
Торцовд тавигдах шаардлага	<p>Торцов нь авч явахад хялбар байхаар зориулалтын хайрцагтай байх</p> <p>Торцов нь бүгд миллиметрийн хэмжээтэй байх</p> <p>Торцов, ишний гангийн хатуулаг HRC50-60 хооронд байх</p> <p>Хайрцаг дотроо 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 27, 30, 32мм-ийн торцов байх ба түүнд таарах түргэн иш, хатуу иш, уртасгагч, согтуу иш, шилжүүлжгч г.м байна. Түүнээс олон хэрэгсэлтэй бол давуу болно. Торцов, ишний эргүүлэх удирдлага нь ½ инч хэмжээтэй байна.</p> <p>Торцовны түргэн иш нь хальтрах гулгахаас сэргийлсэн барзгар резинэн бариултай байна.</p> <p>Өндөр торцов нь 76мм-ээс багагүй өндөртэй байх</p> <p>Өндөр торцовны иж бүрдэл нь 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 27, 30, 32мм-ийн хэмжээтэй торцовтой байх.</p> <p>Торцов, иш нь ашиглалтын явцад зэврэхгүй байхаар никелдсэн байх</p>	

Хийн импактын торцовд тавигдах шаардлага	Торцов нь бүгд миллиметрийн хэмжээтэй байх	
	Хийн багажид зориулагдсан торцов нь хром өндөртэй, хар өнгийн, өндөр эргэлтэд тэсвэртэй гангаар хийгдсэн байх, гангийн хатуулаг HRC-45 байх.	
	3/4 инч удирлагатай өндөр эргэлтийн хар өнгийн торцов нь 32, 33, 34, 35, 36, 38, 41, 42, 43, 46, 48, 50, 52, 55, 60мм-ийн хэмжээтэй байх.	
Бахь, отверткад тавигдах шаардлага	Отвертка, бахьны гангийн хатуулаг нь HRC 58-62 хүртэл байх	
	Отвертка, бахь нь хальтрах, гулгахаас сэргийлсэн, цахилгаан дамжуулдаггүй барзгар резин бариултай байх	
	Бахьны ком нь ашиглалтын зориулалтаас шалтгаалж багадаа 4-н төрөлтэй байх /таслагч, хавчигч, базагч, чимхэгч бахь г.м/	
	Отвертканы ком нь том, жижиг, урт, богино, нэмэх хасах хэлбэрийн 25ш-ээс багагүй тоотой байх.	
	Отвертканы уртын хэмжээ 5см-15см байх	

Гинж, уян татлаганд тавигдах шаардлага	Гинж нь даац, уртыг мэдээллэсэн шошготой, баталгаажуулсан байх Гинжний салаа бүрийн урт ижил байх ба гинж сойгчтой байх		# 
	Уян татлага нь даац, уртыг мэдээллэсэн шошготой байх, баталгаажуулсан байх		
	Уян татлага нь хавтгай хэлбэрийн байх ба 2 үзүүрт холбох гогцоотой байх		
	Гинж холбох хэрэгсэл /Shackle/ нь даацын мэдээлэлтэй байх		#####
Хийн импактад тавигдах шаардлага	1/2 инч удирдлагатай хийн импакт нь 850 Nm болон түүнээс дээш эргэх хүч гаргадаг байх		
	Эргэх чиглэлийг өөрчилдөг байх ба хурдыг тохируулдаг удирдлагатай байх		

	<p>$\frac{3}{4}$ инч удирдлагатай хийн импакт нь 1300Nm болон түүнээс дээш эргэх хүч гаргадаг байх</p>	
<p>Өрөм иж бүрдэлд тавигдах шаардлага</p>	<p>Өндөр эргэлтэд тэсвэртэй таслагч төрлийн CO-HSS гангаар хийгдсэн байх, /HSS-high speed steel/</p> <p>Өрөмний хэмжээ 1, 1,5, 2, 2,5, 3, 3,5, 4, 4,5, 5, 5,5, 6, 6,5, 7, 7,5, 8, 8,5, 9, 9,5, 10, 10,5, 11, 11,5, 12, 12,5, 13мм-ийн хэмжээтэй байх</p> <p>Гар дриллд ашиглах зориулалттай байх</p>	
<p>Тусгай түлхүүрийн их бүрдэлд тавигдах шаардлага</p>	<p>Багажид зориулагдсан гангаар хийгдсэн байх, Хатуулаг HRC52-55 байх.</p> <p>Тусгай түлхүүрийн иж бүрдэл нь 1,5, 2, 2,5, 3, 4, 5, 6, 7, 8, 10мм-ийн хэмжээтэй байна. Хэмжээ бүр дээр тэмдэглэгээтэй байх</p> <p>Тусгай түлхүүр нь 6н талтай байх.</p>	
<p>Дугуй засварын хийн багажд Хүчний багаж</p>	<p>Төмөр тросс зүлгэх хийн зүлгүүр</p> <p>Өндөр хурдтай 0-20000 1/мин/ 6.2 бар/ 0.3kW/ урт: 210 мм/жин: 0.85 kg</p>	
<p>Хүчний багажд тавигдах шаардлага</p>	<p>$\frac{1}{2}$ хэмжээтэй иш буюу хийн инпакт оролттой.</p> <p>$\frac{3}{4}$ хэмжээний гаралтай.</p> <p>46мм хүртэл хэмжээтэй торцрвны эргүүлэх хүчин чадалтай.</p> <p>400Nm хүртэл эргэх хүчний оролттой байх.</p> <p>4000Nm хүчний гаралтай байх.</p> <p>Зориулалтын хайрцаг савтай байх ба дагалдах хэрэгсэл нь бүрэн байна.</p>	<p>#####</p> <p>#</p>  <p>#####</p> <p>#</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
ЗАСВАРЫН БАГАЖ, ХЭРЭГСЛЭЛ	Хийн хүчний багаж /High torque multiplier/	1	КОМ	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ны төв агуулах дээр бууна.	Гэрээ байгуулагд аж, захиалга өгсөнөөс хойш 10 хоног	Захиалагч хойш 7 хоног	
	¾ инчийн хийн импакт	1	КОМ				
	½ инчийн хийн импакт	4	КОМ				
	хийн импактын торцов (10-32мм ½)	4	КОМ				
	хийн импактын торцов (32-56мм ¾)	1	КОМ				
	Дугуй засварын хийн багаж	4	КОМ				
	Амтай түлхүүр	4	КОМ				
	Торцоовны иж бүрдэл	4	КОМ				
	Урт торцоовны иж бүрдэл	4	КОМ				
	Гинж /2 салаа, 3 метр, 4тн/	2	Ш				
	Гинж /4 салаа, 4 метр, 4тн/	2	Ш				
	Гинж дэгээ Холбох хэрэгсэл /Shakle 6тн/	2	Ш				
	Гинж дэгээ Холбох хэрэгсэл /Shakle 2тн/	2	Ш				
	Уян татлага /4 метр, 4 тн/	2	Ш				
	Уян татлага /3 метр, 2 тн/	2	Ш				
	Отверка иж бүрдэл	4	КОМ				
	Бахь иж бүрдэл	4	КОМ				
	Өрөм иж бүрдэл	4	КОМ				
Тусгай түлхүүрийн иж бүрдэл	4	КОМ					

Тав. **ЖИШИГ МАЯГТ**
1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] ажлын хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1 Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан барааг технологийн дагуу нааж гүйцэтгэсэний дараа Захиалагч шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Нийлүүлэгч тал хариуцна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1.1** нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2.1 Захиалагчийн гаргасан захиалгын тоог үндэслэж технологийн дагуу нааж ажлыг гүйцэтгэх;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Төлбөр (ГЕН-7)**
- Төлбөр: Бараа хүлээлцсэн акт, нийлүүлэгч талын нэхэмжлэлийг үндэслэн захиалагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг төлнө.
- Төлбөрийг ажлын гүйцэтгэлээр буюу тухайн гаргасан захиалгын дагуу нэхэмжлэл, барааг нааж гүйцэтгэсэн болон хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн барааг нааж гүйцэтгэсэнээс хойш ажлын 10 хоногт төлнө.
- 4. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 1.1** Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хоногт 0.5 хувийн алданги тооцно.
- Нийт ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувь байна.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.